



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

“Соёлын биет өвийг таньж тогтоох
шинжээчийн зөвлөл”-ийн
журмыг шинэчлэн батлах тухай

Соёлын сайдын 2022 оны “Дүрэм, бүтэц шинэчлэн батлах тухай” А/116 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм”-ийн 3.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн эрхлэх асуудалд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй “Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөлийг холбогдох журамд заасны дагуу ажиллуулах, шийдвэр дүгнэлт гарган танилцуулахыг Зөвлөлийн дарга (М.Оюунтулга)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Д.Нарантуяа)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2023 оны А/04 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



1724010163

ДАСАУТ 2024 онii harimt\TUSHAAI.docx

مَعْلُومٌ مَعْلُومٌ مَعْلُومٌ
مَعْلُومٌ مَعْلُومٌ مَعْلُومٌ

مختصر موسی

جواب

~~مکانیزم~~ ~~و مکانیزم~~

«بِحَمْدِهِ مَرْ وَكَفُوْ بَعْدَ دَسْكُوْ بَعْشَتَسْوَ»

«مقدمة ودفعت بالشجاعين وبهمسو مفسد» / ٦٦٦ فتن مطردة مع

۶ فصلن سوچمیک ور و فرمیسنسیم «عنهای مهندو مهندیمه و مهندو مهندی» - م ۷۰ فرد دستیم در

بحدائقِ حبیبِ مصطفیٰ سویں :

٦٠ .. مەدىھىھەم و مەلۇم ئەرىنىم و ئەلىتھىھەم دەم ۋەنەھىم دەم ئەرىنىم دەم بەزىبىغە سەستەھىم فو بېسىكەدەم ئەمىھىھەم

رسول مصطفیٰ وہ رہنگار و فحیض عتید ..

(۷) .. مهردادیم را بگردیدم و نشیم میتوانیم بعذیسو در سریزیم، به محمد فهمیه نام نیستم من میخشم)

(مذکور) - و متناسب است ..

۴۰/۴ فصل معرفی مردم افغانستان در عکس های این صفحه میتوانید آشنایی باشید.



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2024 оны 01 дугээр сарын 18.-ны өдрийн
A/05 дугаар тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТ
9104208 ХНТ1839
1118155933

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ
СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ТАНЬЖ ТОГТООХ ШИНЖЭЭЧИЙН
ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтад заасан соёлын биет өвийг таньж тогтоох, тодорхойлох, дүгнэлт гаргах (цаашид Таньж тогтоох гэх) чиг үүрэг бүхий Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх) -ийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь Соёлын өвийн үндэсний төвийн дэргэдэх орон тооны бус зөвлөл байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, хэлэлцээр, энэ журмыг удирдлага болгоно.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагаандaa шударга ёс, ил тод байх, хууль дээдлэх зарчмыг баримтална.

Хоёр. Үндсэн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан соёлын биет өвийг таньж тогтоох ажлыг гүйцэтгэнэ.

2.2. Соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр таньж тогтооно.

2.3. Соёлын биет өвийг таньж тогтоохдоо биетээр үзэж, баримтжуулан судлан шинжилсний үр дүнд дүгнэлт, тодорхойлолт гаргана.

2.4. Шинжилгээ судалгааны үр дүн нь тухайн соёлын биет өвийг таньж тогтоох, тодорхойлолт үйлдэх, дүгнэлт гаргах үндэслэл болно.

2.5. Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах талаар санал, зөвлөмж гаргаж болно.

Гурав. Зөвлөлийн бүрэлдэхүүн

3.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Үндэсний төвийн мэргэжилтнүүд болон холбогдох мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл байна.

3.3.Үндэсний төвийн шинжээчийн төлөөлөлд Бүртгэл, мэдээллийн газар, Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар, Сэргээн засварлах газар, Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын мэргэжилтэн байна.

3.4.Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын шинжээчийн төлөөлөл нь музей, түүх, угсаатны зүйн хүрээлэн, археологийн хүрээлэн, палеонтологийн хүрээлэн, геологийн хүрээлэн, их дээд сургууль болон шашин судлал, урлаг судлал зэрэг шинжлэх ухааны чиглэлээр ажилладаг, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн дадлага туршлагатай эрдэмтэн судлаачид байна.

3.5.Зөвлөл нь 45-55 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа

4.1.Зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт гаргасан өмчлөлийн маргаангүй, гарал үүсэл нь тодорхой иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд хамаарах түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг таньж тогтоон тодорхойлолт гаргах,

4.1.2.Хууль, хяналтын байгууллагад шалгагдаж буй эд зүйл болон байгууламжийг эрх бүхий байгууллагын хүсэлт, шийдвэр, тогтоолын дагуу соёлын биет өв мөн эсэхийг таньж тогтоон, шинжээчийн дүгнэлт гаргах,

4.1.3.Олон Улсын шуудан илгээмж, тээвэр логистикийн байгууллагаас ирүүлсэн эд зүйлийг таньж тогтоон, тодорхойлох,

4.1.4.Шаардлагатай тохиолдолд соёлын биет өвд хамаарах эд өлгийн зүйлийн бүтэц, найрлагыг өөрийн болон итгэмжлэгдсэн лабораторид тогтоох,

4.1.5.Соёлын биет өвийг таньж тогтоох чиглэлийн дагуу шинжилгээ, судалгааны мэдээллийн сан үүсгэх.

4.2.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

4.2.1.Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга нар удирдана.

4.2..2.Хурлын тов (огноо, цаг, хурал хийх газар), хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нар харилцан зөвшилцэж тогтоох ба Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын тов, хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг хурал болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлийн гишүүдэд хүргүүлсэн байна.

4.2.3.Зөвлөлийн хурал нь соёлын биет өвийн төрөл зүйл, тоо ширхээс хамаарч холбогдох чиглэл тус бүрээр мэргэшсэн 5-аас доошгүй, сондгий тооны гишүүдийн бүрэлдэхүүнтэй хуралдаж, соёлын биет өвийг таньж тогтоох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.2.4. Зөвлөл нь таньж тогтоох эд зүйлийг эзэмшигч, өмчлөгч болон холбоотой этгээдийг хуралдаанд урьж, нэмэлт мэдээлэл авч болно.

4.2.5. Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар зөвлөлийн гишүүн бус, мэргэшсэн төлөөллийг нэмэлтээр хуралд оролцуулж болно.

4.2.6. Хурлын үйл ажиллагаанд Зөвлөлийн гишүүд биечлэн оролцно.

4.2.7. Зөвлөлийн гишүүд хуралд хүндэтгэх шалгаанаар оролцохгүй болсон тохиолдолд саналаа цахим болон цаасан хэлбэрээр баталгаажуулж өгөх боломжтой. Энэ тохиолдолд таньж тогтоох эд зүйлийг биетээр харсан байх шаардлагатай.

4.2.8. Зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналааар асуудлыг шийдвэрлэнэ.

4.3. Соёлын биет өвийг таньж тогтоохдоо хэв шинж, хийсэн арга ажиллагаа, материал хэрэглэгдэхүүн, хийц, холбогдох он цаг, зориулалтын талаар тодорхойлолт, жин хэмжээ, онцлог, баримтжуулна. Шаардлагатай тохиолдолд орц, найрлагыг тодорхойлж болно.

4.4. Хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тогтоолд дурдсан таньж тогтоох асуудлыг Ерөнхий технологич, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан шинжээч, соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой таньж тогтоох асуудлыг Ерөнхий бүртгэл мэдээллийн санч нар тус тус хариуцна.

4.5. Хууль, хяналтын байгууллагаас ирүүлсэн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тогтоолд дурдсан таньж тогтоох асуудлыг ажлын 14 хоногт, соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой таньж тогтоох асуудлыг ажлын 30 хоногт багтаан шийдвэрлэж хариуг хүргүүлнэ.

4.6. Таньж тогтоох эд зүйлийн тоо хэмжээ, төрөл зүйл, онцлогоос хамааран 4.5-д заасан хугацааг 30 хүртэлх хоногоор сунгаж болох бөгөөд энэ тохиолдолд хүсэлт гаргасан талд бичгээр мэдэгдэнэ.

4.7. Зөвлөлийн ажлын ачааллыг зохицуулах зорилгоор журмын 4.1.1-д заасан таньж тогтоох эд зүйлийн тоо хэмжээнд сараар хязгаарлалт тогтоох ба тухайн сард 1 хүсэлтэд дурдагдсан таньж тогтоолгох эд зүйлийн тоо 200 ширхэг байна.

4.8. Зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн дүгнэлт, тодорхойлолт гаргах бөгөөд дүгнэлт, тодорхойлолтыг тухайн өвийг таньж тогтоосон зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Соёлын өвийн үндэсний төвийн захирал, Зөвлөлийн дарга, Бүртгэл, мэдээллийн газрын дарга, Авран хамгаалах эрсдэлийн судалгааны газрын даргад танилцуулж, баталгаажуулан хүсэлт гаргасан талд албан бичгээр хүргүүлнэ.

4.9. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий технологич, Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч нар таньж тогтоосон соёлын биет өвтэй холбоотой баримт бичгийн бүрдүүлэлтийг хийж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд төрөлжсөн хөмрөг үүсгэн хүлээлгэн өгнө.

4.10. Зөвлөл нь үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Соёлын өвийн үндэсний төвийн захиралд танилцуулна.

Тав. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

5.1. Зөвлөлийн гишүүн нь дараах эрх эдэлнэ.

5.1.1. Зөвлөлийн даргын эрх олгосноор зөвлөлийн хурлыг удирдах,

5.1.2. Зөвлөлийн хуралд оролцож, соёлын биет өвийг хадгалж хамгаалах талаар асуудал боловсруулж, зөвлөлийн хуралд санал оруулах,

5.1.3. Шаардлагатай үед өвд холбогдох материалтай танилцах, санал дүгнэлт гаргах,

5.1.4. Судалгааны ажилд оролцох, хэрэгжилт, үр дүнгийн талаар санал боловсруулж танилцуулах,

5.1.5. Энэ журмын 6.2-т заасан урамшуулал авах.

5.2. Зөвлөлийн гишүүн нь дараах үүрэг хүлээнэ.

5.2.1. Зөвлөлийн хурал, бусад үйл ажиллагаанд биечлэн оролцож санал, зөвлөмж гаргах,

5.2.2. Зөвлөлийн хурлаас гаргасан аливаа шийдвэрийг дагах,

5.2.3. Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд мэдээлэх тохиолдолд Соёлын өвийн үндэсний төвийн захирал болон Зөвлөлийн даргаас зөвшөөрөл авч, албан ёсны байр сууринаас хандах,

5.2.4. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын хүрээнд гишүүдийн илэрхийлсэн байр суурь болон хэлэлцсэн асуудалтай холбоотой мэдээ, мэдээллийг дамжуулахгүй байх,

5.2.5. Ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх, хамаарал бүхий этгээдтэй холбоотой сонирхлын зөрчил үүссэн бол тухай бүр мэдэгдэж дүгнэлт гаргахаас татгалзах (ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлээр баталгаажуулна),

5.2.6. Шинжээчийн зөвлөлийн хурлаар оруулж эд өлгийн зүйлтэй холбогдох мэдээллийн нууцыг бусадад түгээх, задруулах, мэдээлэл солилцохыг хориглоно.

5.2.7.5.2.6 дахь заалтад тусгагдсан агуулгын хүрээнд шинжээчийн зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж эрх, үүргээ баталгаажуулна.

Зургаа. Таньж тогтоох эд зүйлийг хүлээлцэх,
холбогдох баримт бичгийн бурдэл

6.1. Зөвлөл нь таньж тогтоох эд зүйлийг журмын 2.3-т заасны дагуу биетээр нь хүлээн авч, шинжлэн дүгнэж, буцаан хүлээлгэн өгнө.

6.1.1. Таньж тогтоох эд зүйлийг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг Ерөнхий сэргээн засварлагч, Сан хөмрөгч, Зөвлөлийн нарийн бичгийн дарга нар хариуцан зохион байгуулна.

6.1.2. Журмын 4.1.1, 4.1.2-т заасан эд зүйлийг хүлээн аваходаа нэг бүрчлэн тоолж, тэмдэглэл хөтлөн, гарын үсгээр баталгаажуулж, сан хөмрөгийн өрөөнд тусгайлан хадгална.

6.1.3. Эд зүйлийг таньж тогтоон, дүгнэлт, тодорхойлолт гарсны дараа зөвхөн хүсэлт гаргасан байгууллага, түүнийг төлөөлөх эрх бүхий ажилтан, хувь хүнд нэг бүрчлэн тоолж, тэмдэглэл хөтлөн баталгаажуулж, буцаан хүлээлгэн өгнө.

6.2. Энэ журмын 4.1.1-д заасан иргэн, хуулийн этгээдээс дараах бичиг баримтын бүрдлийг хангулсны үр дүнд эд зүйлийг таньж тогтооно.

6.2.1. Өөрийн эд зүйлээ таньж тогтоолгох, бүртгүүлэх тухай өргөдөл, албан бичиг,

6.2.2. Таньж тогтоолгох, бүртгүүлэх эд зүйлийн нэр, зураг, тоо хэмжээ бүхий мэдээлэл (Маяг №1),

6.2.3. Тухайн эд зүйлийн гарал үүсэл болон Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсний дараа холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах тухай баталгаа (Маяг №2),

6.2.4. E-mongolia системээс татах авсан иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн лавлагаа,

6.2.5. Иргэний орших суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа, хуулийн этгээд бол удирдлагын орших суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа,

6.2.6. Соёлын өвийн үндэсний төвийн арилжааны банкны [5001126969](#) (Хас банк) тоот дансанд үйлчилгээний хураамж төлсөн төлбөрийн баримт.

6.3. Журмын 4.1.2-т заасан хууль, хяналтын байгууллага албан бичиг, тогтоол шийдвэрийн хамт ирүүлнэ.

6.4. Журмын 4.1.3-т заасан байгууллага нь албан бичиг, Соёлын өвийн үндэсний төвийн арилжааны банкны [5001126969](#) (Хас банк) тоот дансанд үйлчилгээний хураамж төлсөн төлбөрийн баримтыг тус тус ирүүлнэ.

Долоо. Зөвлөлийн үйл ажиллагааны хураамж, зардал

7.1.Энэхүү журмын 4.1.1-д заасан хувь хүн, хуулийн этгээдийн соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээг төлбөртэй явуулна.

7.2.Хууль хяналтын байгууллага нь мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд орон нутагт шинжээчээр ажиллуулах тохиолдолд томилолтын зардлыг хариуцна.

7.3.Соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээний нэгж эд зүйлийн үнийн тариф 20,000 (хорин мянга) төгрөг байна.

7.4.Таньж тогтоох үйлчилгээний хураамжийг тухайн жилийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж Соёлын өвийн үндэсний төвийн захирлын тушаалаар шинэчлэн тогтоож болно.

7.5.Соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээний хураамжийг улирал тутам нэгтгэж, үндэсний төвийн төрийн сангийн 100900034426 тоот дансанд шилжүүлэн захиран зарцуулах эрхийг нээлгэж дараах зардуудад тус тус хуваарилан зарцуулна.

7.5.1.Шинжээчийн зөвлөлийн гишүүдийн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд (НДШ, ХАОАТ)-40%,

7.5.2.Соёлын биет өвийг таньж тогтоох үйл ажиллагааны зардалд-30% (Багаж, техник хэрэгсэл, эд хогшил, хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, шуудан холбоо, тээвэр шатахуун гэх мэт ургал зардал),

7.5.3.Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөлд ажиллах ажилтнуудыг чадавхжуулах сургалт-30% (дотоодын болон Олон Улсын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлнэ).

7.6.Таньж тогтоох үйлчилгээний хураамжийг төлөхдөө хувь хүн өөрийн овог нэр, регистрийн дугаар, хуулийн этгээд байгууллагын нэр, регистрийг бүрэн бичиж өгсөн тохиолдолд Е-баримт олгоно. Хэрэв холбогдох мэдээлэл дутуу тохиолдолд Е-баримтыг нөхөн олгохгүй.

7.7.Зөвлөлийн гишүүдэд олгох цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын хэмжээг гишүүдийн үүрэг, оролцоо, шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон байдлыг харгалзан Зөвлөлийн хурлаар дүгнэж хагас, бүтэн жилээр олгоно.

Найм. Зөвлөлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1.Улс төр, бүлэглэл, албан тушаалтны нөлөөлөл, шахалт дарамтад өртөж, тэдний ашиг сонирхлыг төлөөлөх,

8.2.Нийтэд мэдээлээгүй мэдээ, мэдээллийг өөрийн болон бусдын эрх ашигт нийцүүлэн урвуулан ашиглах,

8.3.Соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээний төлбөрийг зориулалтын бусаар ашиглах, зарцуулах.

Ec. Хяналт, хариуцлага

9.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд байгууллагын Дотоод хяналтын ажилтан хяналт тавина.

9.2. Журмын 8.1, 8.2, 8.3 дахь заалтыг зөрчсөн тохиолдол илэрвэл Соёлын өвийн үндэсний төвийн хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

---xXx---

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Албан тушаал:	Ажиллаж байгаа байгууллага:	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм Үгүй

Тийм Үгүй

Хоёр Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийллэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав Сонирхыны зарчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хурээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, уйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанад нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв.Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

/......./

/албан тушаал/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх Тийм Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

/......./

/албан тушаал/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

СОЁЛЫН ӨВИЙН УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНД
БҮРТГҮҮЛЭХ ЭД ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Өмчлөгч, эзэмшигчийн нэр: овогтой

Эд зүйлийн мэдээлэл:

Д/д	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Материал	Төрөл зүйл, зориулалт
1				

Өргөдөл гаргасан:

_____ /

/ Овог, нэр/

/ _____ /

/Албан газар, албан тушаал/

20.... оны сарын -ны өдөр

---xXx---

БАТАЛГААНЫ МАЯГТ

Нэг. Үнэн зөв мэдээлэл ирүүлснийг илэрхийлсэн байдал

Монгол Улсын иргэн овогтой би /Регистрийн дугаар/ Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан (СӨҮНБМС)-д бүртгүүлэх хүсэлт гаргаж буй эд зүйлийн гарал үүсэл болон өөрийн талаарх мэдээлэл, тодорхойлолтыг үнэн зөв болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хоёр. Хаягийн мэдээлэл

Оршин суугаа хаяг: аймаг/хот сум/дүүрэг баг/хороо гудамж./хотхон байр тоот		
Ажил эрхлэлтийн төрөл: <input type="checkbox"/> Төрийн байгууллага <input type="checkbox"/> Төрийн өмчит байгууллага <input type="checkbox"/> Хувийн хэвшил <input type="checkbox"/> Төрийн бус байгууллага		
Албан тушаалын нэр:	Ажлын газрын нэр:	Ажлын газрын хаяг:
Утасны дугаар:	Шаардлагатай тохиолдолд холбоо барих хүний утасны дугаар:	Цахим шуудангийн хаяг:

Гурав. Мэдүүлгийн маягт хүлээн зөвшөөрснийг илэрхийлсэн байдал

Монгол Улсын иргэн овогтой би дараах хууль тогтоомжид заасан заалтыг хүлээн зөвшөөрснийг үүгээр мэдэгдэж байна.

2.1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль

20.8. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангцаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.

33.2.1. соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох;

33.2.3. худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэрэгээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх;

33.2.5. алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

2.2. Зөрчлийн тухай хууль

9.7. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих:

1.1. соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалаалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй;

1.2. соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй;

Дөрөв. Баталгаажуулалт

Би энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

..... / /

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

/Огноо/

---xXx---